



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

“Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д өөрчлөлт оруулах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дах заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1 дүгээр хэсэгт дараах агуулга бүхий 5.1.6 дугаар заалтыг нэмсүгэй: “

“5.1.6. Даатгагчийн энгийн хувьцааны 10-аас доош хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг бусдад шилжүүлэх, худалдах тохиолдолд Хороонд мэдэгдэж бүртгүүлнэ”

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД

001218